



**ОРХОН АЙМГИЙН  
ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧДИЙН ХУРЛЫН  
ТОГТООЛ**

2024 оны 04 дугаар сарын 29

Дугаар 19/01

Баян-Өндөр сум

Хуралдааны дэг батлах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 46 дугаар зүйлийн 46.2, 46.9 дэх хэсэг, 48 дугаар зүйлийн 48.1 дэх хэсгийг тус тус үндэслэн аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлаас ТОГТООХ НЬ:

1. Аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Ээлжит XIX хуралдааны дэгийг хавсралтаар баталсугай.

2. Хуралдааны дэгийг мөрдөж ажиллахыг аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Төлөөлөгчид, Хуралдаанд оролцогчдод үүрэг болгосугай.

ДАРГА



Д.МӨНХБАТ

Аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2024 оны 04 дүгээр сарын 29-ний өдрийн Ээлжит XIX хуралдааны 19/01 дүгээр тогтоолын хавсралт

## АЙМГИЙН ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧДИЙН ХУРЛЫН ЭЭЛЖИТ XIX ХУРАЛДААНЫ ДЭГ

Аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 8 дахь удаагийн сонгуулийн Ээлжит XIX хуралдаан 2024 оны 04 дүгээр сарын 29-ний өдрийн 09:00 цагт аймгийн Нутгийн удирдлагын ордны А.Амарын нэрэмжит их танхимд эхэлнэ.

Хурлын хуралдаанд аймгийн Засаг дарга, аймгийн Засаг даргын орлогч, Ажлын албаны дарга, хэлтсийн дарга, мэргэжилтнүүд, аймгийн ЗДТГ-ын дарга, хэлтэс, алба, агентлагийн удирдлагууд, мэргэжилтнүүд, хэвлэл мэдээллийн байгууллагын ажилтнууд оролцоно.

1. "Жаргалант сумын хамгаалалтад байх түүх, соёлын үл хөдлөх дурсгалын жагсаалт батлах" тухай

10 мин

2. "2024-2025 оны Эрдэнэт хотын болон Хөдөө аж ахуйн өвөлжилтийн бэлтгэл хангах арга хэмжээний төлөвлөгөө батлах" тухай

20 мин

3. "Аймгийн 2024 оны төсөвт зохицуулалт хийх, 2023 оны төсвийн шилжих үлдэгдлийн жагсаалт батлах" тухай

10 мин

4. "Орон нутгийн сонгуулийн тойрог, мандатын тоо, нутаг дэвсгэрийн төвийг тогтоох" тухай

15 мин

5. "Аймгийн Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажлыг зохицуулах салбар зөвлөлийн бүрэлдэхүүнд өөрчлөлт оруулах" тухай

10 мин

6. "Аймгийн ИТХ-ын Ажлын албаны бүтэц, орон тоог шинэчлэн батлах" тухай

10 мин

7. Хуралдааны хэлэлцэх асуудлын төлөвлөгөөний төслийг танилцуулж, төсөлд нэмэлт өөрчлөлт оруулах санал байгаа эсэхийг тодруулж, санал хураалт явуулж, олонхын саналаар батлуулна.

8. Аймгийн ИТХ-ын Ээлжит XIX хуралдааны дэд даргыг нэр дэвшүүлж, санал хураалт явуулж, олонхын саналаар сонгуулна.

9. Хэлэлцэж байгаа асуудлаар гарах шийдвэрийн төслийг эцэслэн боловсруулах Редакцын комиссыг 3 хүртэлх Төлөөлөгчдийн бүрэлдэхүүнтэй байгуулж ажиллуулна. Редакцын комиссын анхдугаар хурлыг хуралдааны удирдлагын зүгээс хийлгэж, даргыг сонгуулан хуралдаанд мэдэгдэж хурлын материалыг хүлээлгэн өгнө.

10. Хуралдаанд оролцож байгаа Төлөөлөгчдийн ирцийг mlsp.mn программаар бүртгэнэ.

11. Тухайн асуудлаар асуулт асуух, санал хэлэх Төлөөлөгчдийн нэрсийг хуралдааны удирдлагын зүгээс mlsp.mn программаар урьдчилан авч дараалалд оруулна. Төлөөлөгчид тус программын санал гэсэн цэс дээр даран өөрийн нэрээ урьдчилан өгнө.

12. Хүндэтгэн үзэхээс бусад шалтгаанаар Хурлын Төлөөлөгч хуралдаанд оролцохгүй байх, хуралдааныг орхиж гарахыг хориглоно. Хуралдааныг орхиж гарсан тохиолдолд хуралдаанд оролцож эсрэг санал өгсөнд тооцож санал хураалт явуулна.

13. Тухайн хэлэлцэж байгаа асуудлаар Төлөөлөгчдийн асуулт асуух, санал хэлэх хугацаа хүн тус бүрд эхний удаа 3 хүртэл минут, хоёр дахь удаа 1 хүртэл минут байна.

14. Тухайн хэлэлцэж байгаа асуудлаар эцсийн шийдвэр гаргах, асуулт, хариулт, санал, шүүмжлэлийг таслахдаа санал хураалт явуулж олонхын саналаар шийдвэрлэнэ.

15. Хэлэлцэж байгаа асуудлаар цөөнх болсон Төлөөлөгчийн үндэслэл, саналыг сонсож, дахин нэг удаа санал хураалт явуулж болно.

16. Асуулт тавих, үг хэлэх, санал шүүмжлэл гаргах зөвшөөрлийг хуралдааны удирдлага олгож тогтоосон хугацааг баримтална.

17. Санал, шүүмжлэлийг хуралдааны удирдлагад бичгээр өгч болно. Бичгээр өгсөн санал шүүмжлэлийг хуралдааны удирдлага танилцуулах бөгөөд шаардлагатай гэж үзвэл Редакцын комисст шилжүүлнэ.

18. Утга агуулгын болон ажлын уялдаа холбоог харгалзан тухайн асуудлыг шаардлагатай бол нэг багц асуудал болгон хэлэлцэж, асуулт хариулт, санал шүүмжлэлийг нэг мөр явуулж болно.

19. Хэлэлцэж байгаа асуудал нь хүний хувийн болон эмзэг мэдээлэл бол тухай асуудлыг хаалттай хэлэлцэж, хурлаас гарах шийдвэрийг иргэд олон нийтэд нээлттэй танилцуулна.

20. Хэлэлцэж байгаа асуудалтай холбогдуулан Намын бүлэг завсарлага авч болох бөгөөд завсарлагын хугацааг 1 цаг хүртэл байна. Завсарлага авснаас хойш бүлгээс тухайн асуудалд нэгдсэн байр суурь илэрхийлж хуралдаанд оролцоно.

21. Намын бүлэгт олгосон завсарлагын хугацаа сунгах шаардлага гарвал хуралдаанаар шийдвэрлэх бөгөөд тогтоосон хугацааг чанд баримтална.

22. Аймгийн ИТХ-ын Төлөөлөгч нь хуралдаанаар хэлэлцэх асуудал болон шийдвэрийн төслийг боловсруулах, шийдвэр гаргахад оролцох асуудлаар ашиг сонирхлын зөрчилтэй буюу зөрчил үүсэж болзошгүй гэж үзвэл аймгийн ИТХ-ын дарга болон аймгийн ИТХ-ын эрх бүхий албан тушаалтанд мэдэгдэл гаргана.

23. Хуралдааныг 2 цаг тутам 15 минутын завсарлагаатайгаар явуулна.

24. Өдрийн их завсарлага нэг цагийн хугацаатай байна.

25. Хуралдаан тухайн ажлын өдөр багтахгүй бол үргэлжлүүлэх аль эсвэл дараачийн өдөр шилжүүлэх асуудлыг санал хураалт явуулж олонхын саналаар шийдвэрлэнэ.

26. Хуралдаанд урилгаар оролцогсад зөвлөх эрхтэй оролцох бөгөөд хуралдааны удирдлагаас зөвшөөрөл авч 3 хүртэл минут үг хэлж болно.

27.Хуралдааны мэдээллийг орон нутгийн “NB HD” телевиз шууд дамжуулна. Мөн орон нутгийн бусад телевиз, сайт зэрэг хэвлэл мэдээллийн байгууллагуудаар дамжуулан иргэдэд хүргэх боломжоор ханган ажиллана.

28.Хуралдааны үед иргэдтэй харилцах 7035-0494 дугаарын утас ажиллана. Иргэдтэй харилцах утаснаас ирүүлсэн хувь хүний нэр төртэй холбоотойгоос бусад хэлэлцэж буй асуудалтай холбоотой саналыг багцлан хуралдаанд танилцуулж, шаардлагатай бол холбогдох албан тушаалтнаар хариу тайлбар хэлүүлнэ. Харин хэлэлцэж буй асуудалтай хамааралгүй иргэдийн ирүүлсэн хүсэлт, саналыг хуралдаанд танилцуулахгүйгээр шууд холбогдох албан тушаалтанд хүргүүлнэ.

29.Хуралдааны дарга хэлэлцэх асуудлыг хуралдааны дэгийн дагуу амжилттай явагдаж өндөрлөснийг дүгнэж, хуралдааныг хаасныг мэдэгдэнэ.

30.Хуралдааны тэмдэглэлийг аймгийн ИТХ-ын Ажлын албаны Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажлыг зохицуулах салбар зөвлөл хариуцсан ажилтан хөтөлнө.

**АЙМГИЙН ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧДИЙН  
ХУРЛЫН ЭЭЛЖИТ XIX ХУРАЛДААН**